ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
АЛБАН БУС-НАСАН ТУРШИЙН
БОЛОВСРОЛЫН ТӨВ

# “Ёс зүйн зөвлөл”-өөс зохион байгуулсан үйл ажиллагааны хагас жилийн тайлан

2023 он

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН АЛБАН БУС-НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

1. Ёс зөвлөлийн 2022-2023 оны ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулсан.

ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 оны сарын өдөр

| № | Үйл ажиллагаа | Хэнд | I улирал | | | II улирал | | | III улирал | | | IV улирал | | | Хариуцах эзэн | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | | |
| 1 | Төлөвлөгөө хийж батлуулах | Албан хаагчид | | | | | | | | | | | | | Гишүүд | |
| 2 | Ёс зүйн зөвлөл 2023 онд санал асуулга | Албан хаагчид | | | | | | | | | | | | | Гишүүд | |
| 2 | Багш ажилтны ёс зүйн дүрэм танилцуулах | Албан хаагчид | | | | | | | | | | | | | Б.Эрдэнэдулам | |
| 3 | Байгууллагын соёлыг таниулж, мөрдүүлэх цахим мэдээлэл өгөх | Албан хаагчид | | | | | | | | | | | | | Гишүүд | |
| 4 | Хурал, сургалтын үеийн дэгийг баримтлах чиглэлээр сургалт зохион байгуулах | Албан хаагчид | | | | | | | | | | | | | Гишүүд | |
| 5 | "Би нөлөөлөгч" сургалт зохион байгуулах | Албан хаагчид | | | | | | | | | | | | | С.Анхтуяа Б. Эрдэнэдулам | |
| 6 | Суралцагчдад өсвөр насны хүүхдийн харилцаа, ёс зүйн асуудлын талаар сургалт зохион байгуулах | Суралцагчид | | | | | | | | | | | | | Гишүүд | |
| 7 | Биеэ хэрхэн авч явах сургалт зохион байгуулах | Албан хаагчид | | | | | | | | | | | | | О. Лхагвасүрэн | |
| 8 | Байгууллагаар үйлчлүүлж буй иргэдээс багш ажилчдын харилцааны санал асуулга авах | Албан хаагчид | | | | | | | | | | | | | Гишүүд | |
| 9 | Ёс зүйн асуудлыг хүлээн авч шийдвэрлэн ажиллах | Албан хаагчид | | | | | | | | | | | | | Гишүүд | |
| 10 | "Ёс зүй " аян зохион байгуулах | Албан хаагчид | | | | | | | | | | | | | Гишүүд | |

*Зураг № Төлөвлөгөө*

2. **Санал асуулга**

Ёс зүйн зөвлөлөөс хийх ажлын талаар байгууллагын нийт ажилтан албан хаагчдаас судалгаа авсан бөгөөд цөөн албан хаагч санал ирүүлэв. Үүнд: Харилцаа хандлагын талаарх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах, биеэ хэрхэн зөв авч явах арга техникүүдийн талаарх санал ирүүлсэн.




Зураг № 1 Байгууллагын хуудаст байршуулсан санал асуулга

3. **Ёс зүйн дүрэм танилцуулга**

Байгууллагын удирдлага, албан хаагчдад Боловсрол шинжлэх ухааны сайдын А/545 дугаар тушаалаар 2022 оны 12 дугаар сарын 20-нд шинэчлэгдэн батлагдсан Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг танилцуулж цаашид мөрдөгдөх хэм хэмжээнүүдийг таниулан ажилласан.

Мөн хамт олны дунд эерэг уур амьсгал бүрдүүлэх, шүүмжлэлийг эерэгээр хүлээж авах заалтуудын хүрээнд албан хаагч бүр байгууллагын 5 хүнд сайн зан чанар болон үйлдэл 2, засан сайжруулах зан чанар болон үйлдэл нэгийг бичих даалгавар өгч зөвлөмжүүдийг  хүн тус бүрт хүргүүлэн ажиллалаа.





## 4. Байгууллагын соёлыг таниулах

Байгууллагын пейж хуудсаар дамжуулан Хан-Уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төвийн ажилтан, албан хаагчдын мөрдөн ажиллах байгууллагын соёлын хэм хэмжээнүүдийг постер хэлбэрээр бэлтгэн хүргэж ажиллалаа.












5. Хан-Уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төвийн Боловсрол нөхөн олгох дунд ангийн суралцагдад өсвөр насны хүүхдийн бие, сэтгэлзүйн онцлог нийгмийн хэрэгцээ, бие биетэйгээ харилцахад учирч буй бэрхшээл, тулгамдаж буй асуудлыг хэрхэн даван туулах талаар Харилцаа ёс зүйн боловсролын багш Б.Эрдэнэдулам 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр сургалт зохион байгуулсан.



6. Байгууллагын албан хаагчдын дунд ёс зүйн зөрчил гараагүй.

**Дүгнэлт**

Ёс зүйн зөвлөлөөс шинэ батлагдан гарсан дүрмийг танилцуулах, байгууллагын соёлыг мөрдүүлэх ажлуудын хүрээнд сургалтад нийт албан хаагчдыг бүрэн хамруулж боловсрол нөхөн олгох дунд ангийн суралцагчдадөсвөр насны хүүхдүүдийн хоорондын харилцаа сэдвээр сургалт зохион байгуулсан.

Цаашид Боловсрол шинжлэх ухааны сайдын А/545 дугаар тушаалаар 2022 оны 12 дугаар сарын 20-нд шинэчлэгдэн батлагдсан Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийн хамт олны өмнө хүлээх ёс зүйн хэмжээг баримтлах, хэрэгжүүлэх заалтын хүрээнд нэмэлт сургалтууд болон нөлөөллийн ажлууд зохион байгуулах байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Б.ЭРДЭНЭДУЛАМ

ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН А.БОЛОРМАА

ХЯНАСАН:

СУРГАЛТЫН МЕНЕЖЕР Ч.ГАНТУЯА